

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны . . . дугаар
сарын . . .ны/ий өдрийн . . . дугаар тогтоолын
. . .дугаар хавсралт

Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мах бэлтгэх зорилгоор төхөөрөх малыг орон нутгаас бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үед бэлтгэлийн малд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийх, хорио цээрийн шаардлага хангуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах, малын гоц халдварт болон халдварт өвчин тархах, өвчтэй мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлахаас сэргийлэхэд энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмыг мал худалдах, худалдан авах, тууварлах, тээвэрлэх үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд, орон нутгийн мал эмнэлгийн газар, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг, гэрээт мал эмнэлэг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.14 дэх хэсэгт заасан харилцааг зохицуулна.

Хоёр. Мал бэлтгэлд тавих мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага

2.1. Мал бэлтгэлийг тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт мал худалдаалах төвлөрсөн цэгт явуулна. Мал худалдаалах төвлөрсөн цэгийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн дүгнэлт, саналыг үндэслэн Засаг дарга тогтооно.

2.2. Сум, дүүргийн мал худалдаалах төвлөрсөн цэгийг усны эх булаг, айл, мал болон төмөр зам, хот хоорондын чанартай авто замаас зайдуу, хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд тохиромжтой газарт байгуулна.

2.3. Мал бэлтгэлийн ажлыг тухайн орон нутгийн байршил, газар зүйн онцлог, цаг агаарын байдалтай уялдуулан зохион байгуулна.

2.4. Гоц халдварт болон зоонозын халдварт өвчин сүүлийн 6-12 сар гараагүй сум, нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй малыг гэрээт мал эмнэлэг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эрүүл малыг бэлтгэнэ.

2.5. Мах бэлтгэлд зориулж малчин өрхөөс мал бэлтгэхэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.3 дахь хэсгийн заалт, энэхүү журмын 2.4 дэх хэсгийн заалтын шаардлагыг тус тус хангасан, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан, тарилга, туулгалт хийснээс хойш махыг хүнсэнд хэрэглэх холбогдох зааврын шаардлагыг хангасан байна.

2.6. Мах экспортлоход зориулан байгуулсан тусгаарласан аж ахуйд гоц халдварт болон зоонозын халдварт өвчин сүүлийн 6-12 сар гараагүй, гоц халдварт өвчний эсрэг вакцинаар таригдаж байгаагүй, энэ нь эпидемиологийн судалгаа эмнэл зүйн үзлэг, ийлдсийн түүвэр шинжилгээгээр нотлогдсон сум, орон нутгаас гарал үүсэлтэй малыг ийлдсийн шинжилгээний дээж авсанаас хойш 14-21 хоног өнгөрсний дараа шинжилгээний дүн, эмнэлзүйн байдлыг харгалзан малыг тусгаарлах аж ахуй руу тээвэрлэнэ.

2.7. Бэлтгэж буй малыг толгой дараалан бүртгэлжүүлж (малын төрөл, зүс, нас, хүйс, гарал үүсэл, эмчилгээ, тарилга зэрэг мэдээллийг агуулсан ээмэг, бичил чип суулгаж) мэдээллийн нэгдсэн цахим санд оруулж эцсийн бүтээгдэхүүн бэлтгэх дамжлага хүртэл хянах боломжийг бүрдүүлсэн байна.

2.8. Бэлтгэсэн малыг үйлдвэрт хүлээн авах, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хүртэлх бүх шатанд шилжилт хөдөлгөөн, хяналт, шинжилгээг нэг бүрчлэн бүртгэсэн байх бөгөөд цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэгдсэн байна.

2.9. Өвчний шинж тэмдэгтэй, эсвэл сэжигтэй, тууврын зам даахааргүй сульдаж доройтсон, хэт хөгширсөн, лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн, хээлтэй мал бэлтгэхийг хориглоно

Гурав. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн эрх, үүрэг

3.1. Тухайн орон нутагт мал худалдаалах төвлөрсөн цэг байгуулах санал, дүгнэлт гаргаж Засаг даргаар шийдвэрлүүлнэ.

3.2. Тухайн нутаг дэвсгэрийн малын халдварт өвчний голомт, тархалтын судалгааг үндэслэн бэлтгэлийн мал тууварлах, тээвэрлэх, дамжин өнгөрөх замын маршрут, түр амрах цэгийн байршлыг тогтоох Засаг даргаар шийдвэрлүүлж олон нийтэд мэдээлнэ.

3.3. Үзлэг, шинжилгээгээр эрүүл болох нь тогтоогдсон, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малд гэрээт мал эмнэлэгээс олгосон тодорхойлолтыг үндэслэн, цахим бүртгэлийн системд бүртгэн тууварлах, тээвэрлэхийг зөвшөөрч мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

3.4. Мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасныг үндэслэнэ.

3.5. Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч малд суулгасан бичил чип, дамжуулагчийг ашиглан толгой дараалан цахим хяналт тавих бөгөөд мэдээллийг нэгдсэн цахим сүлжээнд илгээнэ.

3.6. Бэлтгэлийн малд хийсэн үзлэг, шинжилгээгээр сэжигтэй гарсан, тарилга, туулгалтад хамрагдаагүй малыг тусгаарлан хорио цээрт оруулна.

3.7. Эрүүл мэндийн үзлэгээр өвчний шинж тэмдэг, сэжиг илрээгүй малд ям, бруцеллэз, сүрьеэ өвчний шинжилгээг гэрээт мал эмнэлэг, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын лабораториор толгой дараалан хийлгэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Гэрээт мал эмнэлгийн эрх, үүрэг

4.1. Орон нутгийн мал худалдаалах төвлөрсөн цэгт худалдаалах зорилгоор ирсэн мал болон малчин өрхөөс бэлтгэж байгаа малд толгой дараалан үзлэг хийж, тарилга, туулгалтад хамрагдаагүй малыг тусгаарлан урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулна.

4.2. Эрүүл мэндийн үзлэгээр өвчний шинж тэмдэг, сэжиг илрээгүй малд мал эмнэлгийн тасгийн зөвшөөрснөөр ям, бруцеллэз, сүрьеэ өвчний шинжилгээг толгой дараалан хийж, эрүүл болохыг тогтооно.

4.3. Үзлэг, шинжилгээгээр эрүүл болох нь тогтоогдсон, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малыг тууварлах, тээвэрлэхийг зөвшөөрч тухайн орон нутгийн малын халдварт өвчний голомт, тархалтын судалгааг үндэслэн эрүүл мэндийн тодорхойлолт олгоно.

4.4. Бэлтгэлийн малын ээмэгний дугаар, нас, хүйсийг эрүүл мэндийн тодорхойлолтод хавсралтаар бүртгэж мал тууварлагч, тээвэрлэгч этгээдэд мал нэг бүрээр хүлээлгэн өгнө.

4.5. Мал тээвэрлэх тээврийн хэрэгсэлд холбогдох заавры дагуу цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж акт бичиж олгоно.

Тав. Бэлтгэлийн малыг тууварлах, тээвэрлэхэд тавих шаардлага

5.1. Мал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь малд бэртэл гэмтэл учруулахгүй, тавлаг байдлыг хангасан байхаар тоногдсон, мал тээвэрлэхийн өмнө механик цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

5.2. Мал тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэлд мал тээвэрлэхийн өмнө хийгдсэн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийгдсэн тухай баримт, явах маршрут заасан замын хуудас зэрэг дагалдаж явна. Шаардлагатай тохиолдолд хяналтын цэгийн байцаагч нь мал бүрийн шинжилгээний мэдээллийг цахимаар шалгаж баталгаажуулна.

5.3. Зориулалтын тээврийн хэрэгсэлд малын дэвсгэрийг зөвхөн нэг удаа тээвэрлэхэд ашиглана.

Зургаа. Хяналтын цэгийн улсын байцаагчийн эрх, үүрэг

6.1. Хяналтын цэгийн улсын байцаагч нь мал тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд бичиг баримтын үзлэг шалгалт хийж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн зөрчсөн тохиолдолд тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2. Малыг тээвэрлэлтийн явцад хяналтын цэгийн улсын байцаагч малд суулгасан бичил чип, дамжуулагчийг ашиглан толгой дараалан цахим хяналт тавих бөгөөд мэдээллийг нэгдсэн цахим сүлжээнд илгээнэ.

Долоо. Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

7.1. Төв орон нутгийн Мал эмнэлгийн байгууллага мах экспортлоход зориулж байгуулсан тусгаарласан аж ахуйд зориулж мал бэлтгэхэд дараахь үүрэгтэй. Үүнд:

7.1.1. Мал эмнэлгийн байгууллага нь тусгаарласан аж ахуй байгуулах газар, бэлчээр, түүнд зориулан байгалийн хадлан бэлтгэх бүс нутагт сүүлийн 6-12 сар олон улсын худалдааны хоригт өвчин болон байгалийн голомтот өвчний халдваргүй болохыг эпидемиологи, эмнэл зүйн болон ийлдсийн шинжилгээний тандалтаар нотолж мэргэжлийн дүгнэлт гаргана.

7.1.2. Тусгаарласан аж ахуйн байгууламжийн зураг, төслийг хянах, зөвлөх, ашиглалтанд орохоос өмнө мал эмнэлэг, хорио цээрийн хянан магадлагаа хийнэ.

7.1.3. Мах экспортлоход зориулж мал бэлтгэх гоц халдварт өвчингүй аймаг, сум, бүс нутгийг тухай бүрт тогтооно.

7.1.4. Мал бэлтгэх бүс нутагт олон улсын худалдааны хоригт халдварт өвчний тандалт судалгаа хийх ажлыг зохион байгуулж, мах экспортлогч аж ахуйн нэгж болон импортлогч улсыг холбогдох мэдээллээр хангана.

7.1.5. Тусгаарласан аж ахуйн үйл ажиллагаа явуулах мал эмнэлгийн тасаг, шинжилгээ хийх мал эмнэлгийн лаборатори, гэрээт мал эмнэлгийг томилж ажиллуулах бөгөөд мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

7.1.6. Импортлогч улсын шаардлагаар зайлшгүй хийгдэх халдварт өвчний шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний жагсаалтыг батална.

7.1.7. Тусгаарласан аж ахуйд хорио цээрийн дэглэм хэрэгжүүлэх, шинжилгээ, халдваргүйтгэл хийх, малын өтөг бууц, ахуйн хог хаягдал устгах, халдваргүйжүүлэх, өвчинтэй малыг шатааж устгах зэрэг зааврууд болон малын өвс, тэжээл хүлээн авахад тавигдах мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага, гоц халдварт өвчингүй ч үйлдвэрт хүлээн авах шаардлага хангаагүй гологдол малыг тусгаарласан аж ахуйгаас гаргах, хэрэгцээлэх заавар зэргийг улсын малын ерөнхий эмч батална.

Найм. Мал бэлтгэгч, тууварлагч, тээвэрлэгч этгээдийн эрх, үүрэг

8.1. Энэхүү журмын 2.4, 2.5, 2.6 дахь хэсэгт заасан шаардлага хангасан малыг бэлтгэнэ.

8.2. Мал экспортлох зорилгоор байгуулсан тусгаарласан аж ахуйд зориулж мал бэлтгэж байгаа этгээд хуулийн энэхүү журам болон Малын ерөнхий эмчийн баталсан зааврыг мөрдөг болгоно.

8.3. Мах бэлтгэлийн зориулалтаар тууварлах, тээвэрлэх малд тухайн орон нутгийн гэрээт малын эмчээр үзлэг, шинжилгээ хийлгэж эрүүл мэндийн тодорхойлолт авч мал эмнэлгийн тасагт шинжилт хөдөлгөөн хийх бүртгэлд оруулж мал эмнэлгийн гэрчилгээ авна.

8.4. Мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, бэлтгэлд тэнцсэн, мал эмнэлгийн гэрчилгээтэй малыг тууварлаж, тээвэрлэнэ.

8.5. Эрх бүхий байгууллагаас тогтоож өгсөн маршрутаар тууварлаж, тээвэрлэх бөгөөд тухайн орон нутгийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн зөвшөөрсөн газарт зайлшгүй шаардлагаар малыг түр амраах, буулгах, сэлгүүлэн ачиж болно.

8.6. Тээвэрлэлт, тууварлалтын явцад малд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, гэнэт олон мал адил шинж тэмдэгтэй өвчилсөн, хорогдсон тохиолдолд тээвэрлэх, тууварлах үйл ажиллагааг даруй зогсоож, тухайн нутаг дэвсгэрийн засаг дарга, малын эмч болон мал эмнэлгийн тасгийн аль нэгэнд 12 цагийн дотор мэдээлнэ.

8.7. Бэлтгэлийн малыг худалдан авснаас хойш мал төхөөрөх үйлдвэрт хүлээн авах хүртэл бусдын малтай нийлүүлэх, өөр малаар солих, бусдад шилжүүлэх, маршрутын бус замаар тууварлах, тээвэрлэхийг хориглоно.

Ес. Бэлтгэлийн малыг төхөөрөх үйлдвэрт хүлээн авах

9.1. Иргэн, хуулийн этгээд нядлуулах малаа мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн хяналтын дор мал нядлах үйлдвэрт хүлээлгэн өгнө.

9.2. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч тээвэрлэж ирсэн мал нэг бүрийг холбогдох эрүүл мэндийн гэрчилгээ, бусад дагалдах бичиг баримт зэргийг мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүртгэлтэй харьцуулан шалгаж ямар нэг зөрчилгүй тохиолдолд хүлээж авна.

9.3. Маршрутын бус замаар тээвэрлэсэн, дагалдах бичиг баримтгүй, эсвэл засвартай, дамжин өнгөрөх хяналтын цэгийн улсын байцаагчийн баталгаажуулалтгүй, нэгдсэн цахим санд мэдээллийг бүрэн гүйцэд бүртгээгүй, улсын байцаагчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэл сольсон эсвэл зөвшөөрөгдөөгүй цэгт буулгасан зэрэг зөрчил илэрсэн тохиолдолд үйлдвэрт малыг хүлээн авахаас татгалзаж, хорио цээрт оруулж шинжилгээнд хүрэн хамруулна.

Арав. Журмыг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1. Энэ журмын заалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд эрүүлгийн хэрэг хүлээлгэхгүйгээр бол бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийтгэл ногдуулна.